



Хэрэгжилт – хэсэг 2

Raymond Gervais
2023



Агуулга

Энэ хэсэгт:

- ❖ Гүйцэтгэлийг хэмжих хүрээн дэх бүрдэл хэсгүүдийн шинжилгээ
- ❖ Удирдлагын стратегийн найдвартай байдлыг бий болгох
- ❖ Хөтөлбөр болон бодлогын шинжилгээний элементүүд

Гүйцэтгэлийг хэмжих хүрээ: Бүрдэл хэсгүүд ба үнэлгээ



“ҮДСУ-ын гол зүйл нь гүйцэтгэлийн хэмжилт юм”

- Хэрэгжиж буй хөгжлийн интервенцийн гол оролцогч тал, удирдлагын багийг хэрэгжилтийн үйл явц, зорилгын биелэлт, төсөв хөрөнгийн зарцуулалтын талаар мэдээллээр хангах үзүүлэлтүүдийг боловсруулах системчилсэн, тасралтгүй үргэлжлэх чиг үүргийг. OECD Glossary
- Төсөл, хөтөлбөр эсвэл бодлогын хэрэгжилтийн явцыг хянах зорилгоор гол шалгуур үзүүлэлтийн дагуу хүлээгдэж буй үр дүнг бодит үр дүнтэй харьцуулах, мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх үргэлжилсэн үйл явц
- Гүйцэтгэлийн хэмжилт нь хүссэн үр дүндээ хүрч байгаа эсэхийг тодорхойлох болон шаардлагатай тохиолдолд арга барилаа өөрчлөх боломжийг олгодог

Гүйцэтгэлийг хэмжих хүрээ

- Канадын гадаад хэргийн яам ГХХ-г дараахь байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:
- Шийдвэр гаргахад чиглүүлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг [шалгуур үзүүлэлт] сонгох, боловсруулах, ашиглах үйл явц буюу систем.
- ГХХ нь ихэнх тохиолдолд менежерүүдийн төсөл, хөтөлбөрийн амжилтыг (эсвэл алдаа) холбоотой шийдвэр гаргахад ашигладаг гол хэрэгсэл юм. Логик загвар нь төсөл дээр ашиглахад илүү тохиромжтой байдаг бол ГХХ-г хяналт-шинжилгээний систем бий болгоход хэрэглэж болох юм.
- Санаж байх ёстой хамгийн чухал зүйл бол зохих шийдвэр гаргахын тулд менежерүүд үнэн зөв, цаг тухайд нь мэдээллийг олж авах хэрэгцээ байдаг.

Гүйцэтгэлийг хэмжих хүрээний загвар

Тодорхойлолт	Шалгуур үзүүлэлт	Суурь мэдээлэл	Зорилт	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга	Давтамж	Хариуцлага
Дээд түвшнээс эхлэн доод түвшин рүү	Түвшин бүрт тохирох шалгуур үзүүлэлт: SMART	Ялгаатай эх сурвалжууд: Үндэсний болон төслийн хэмжээнд	Бодитой болон хугацаатай байх	Хүртээмжтэй, олон талт, найдвартай, баталгаатай	Мэдээллийг хэрхэн цуглуулах вэ?	Тайлагнах шаардлагын дагуу	Мэдээллийг хэн цуглуулах вэ? Тухайн байгууллагад хангалттай ур чадвар бий юу?

ГХХ-ний бүрдэл хэсгүүд

- **Үр дүнгийн тодорхойлолт:** Эдгээр нь бүх баримт бичигт ижил байх ёстой: Логик загвар, логик хүрээ, ГХХ. ҮДСУ менежерүүд үр дүнг дээд шатнаас доод түвшинд хэмжих ёстой.
- **Шалгуур Үзүүлэлтүүд:** ГХХ нь шалгуур үзүүлэлтүүдийн тодорхойлолтыг өөрчилдөггүй, шалтгаан үр дагаврын хамаарал нь тодорхой болсон эсэхийг үнэлэхэд хамгийн тохиромжтой хэмжих хэрэгсэл хэвээр байна.
- **Суурь түвшин:** Эдгээр нь төсөл, хөтөлбөрийн эхлэлийн тодорхой шалгуур үзүүлэлтийн утга юм. Суурь мэдээллийг тодорхой хугацаанд цуглуулж, үр дүнд хүрэх ахиц дэвшлийг хэмжих эсвэл үнэлэх жишиг болгон ашигладаг.

ГХХ-ний бүрдэл хэсгүүд

- **Зорилтот түвшин:** Энэ нь ирээдүйд тодорхой хугацаанд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр хүрэхийг зорьж буй тодорхой утга эсвэл утгын хязгаарыг илэрхийлнэ. Мөн хөтөлбөрийн үр дүнгийн түвшинд үндэсний болон бүс нутгийн зорилтуудын нийцлийг хангах хэрэгсэл юм.
- **Өгөгдөл-Мэдээллийн эх үүсвэр:** Төсөл эсвэл хөтөлбөрийн түвшинд шалгуур үзүүлэлтүүдийг магадлахад шаардлагатай эх сурвалжууд. Эдгээр нь төслийн тусгай эх сурвалж эсвэл үндэсний эх сурвалж байж болно.
- **Өгөгдөл-мэдээлэл цуглуулах арга:** Чанарын (жишээ нь, фокус бүлгийн хэлэлцүүлэг) болон тоон (жишээ нь, судалгаа) гэх мэт олон аргууд байдаг бөгөөд тэдгээрийг дараагийн илтгэлүүдэд тусгасан болно. Бүх аргын зорилго нь хамгийн найдвартай өгөгдлийг үр ашигтайгаар олж авах явдал юм.

ГХХ-ний бүрдэл хэсгүүд

- **Давтамж:** ГХХ-д шалгуур үзүүлэлтүүдийн цаг хугацааг тогтоох нь шийдвэр гаргахад оролцож буй бүх оролцогч талууд нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэлтэй болох боломжийг олгодог.
- **Хариуцлага:** Мэдээлэл/мэдээлэл цуглуулах үүрэг хариуцлагыг хуваарилах нь хяналт-шинжилгээг хамгийн бага зардлаар тогтмол хийх боломжийг олгоно. Хариуцах оролцогч талууд нь хувь хүн, байгууллага, хэлтэс байж болно. Хариуцагч нь бүх тохиолдолд шалгуур үзүүлэлт, мэдээллийн системийн найдвартай байдлыг хариуцна.

ГХХ нь логик загвар болон оролцогч талуудын хүлээлт, шаардлагын дагуу мониторингийн системийг хэрэгжүүлэхийн тулд төлөвлөгчид болон ХШҮ-ний ажилтнуудаар дамжин хэрэгждэг.

Амжилтад хүрэх түлхүүр нь эдгээр хэлтсүүд хамтран ажиллах явдал юм

ГХХ-ний бүрдэл хэсгүүд: Үр нөлөөний тодорхойлолт

- Бүх тодорхойлолт нь үр дүнд чиглэсэн үү?
- Оролцогч талууд өөрсдийн санаа зовоосон асуудлуудыг тодорхойлолтод тусгасан гэж үзэж байна уу?
- Бүх баримт бичигт тодорхойлолт адил байна уу?
- Өгүүлбэр нь тодорхойлолтыг (хамаарал, нөхцөл байдлын шинжилгээгээр баталгаажуулах, шалтгаан үр дагаврын холбоо гэх мэт) товч тайлбарлаж байна уу?

ГХХ-ний бүрдэл хэсгүүд : Шалгуур үзүүлэлт

- ГХХ-ний бүх түвшинд, тохирох шалгуур үзүүлэлтийг сонгосон үү?
- Тэд тодорхой гарц эсвэл үр нөлөөнд зориулж мэдээллийг цуглуулж эсвэл хэмждэг үү?
- Тэд удирдамжид заасан шалгуурыг хангаж байна уу?
- Цаг хугацаа, зардал, нарийн төвөгтэй байдал гэсэн гурван үндсэн бэрхшээлийг сонголт хийхдээ харгалзан үзсэн үү?
- Хүлээгдэж буй өгөгдөл/мэдээллийг гаргаж өгөх түншүүдийн чадавхийг үнэлэхэд хангалттай цаг хугацаа, дүн шинжилгээ хийсэн үү?
- Хүссэн шалгуур үзүүлэлтүүдийн тоо хэмжээ, чанарын аль алинд нь эрсдэлийн шинжилгээ хийсэн үү?

ГХХ-ний бүрдэл хэсгүүд : Суурь мэдээлэл

- ГХХ-ийн бүх шалгуурт суурь түвшний үзүүлэлт байна уу? Үгүй бол өөр үзүүлэлт тодруулж чадах уу? “0” утгатай суурь үзүүлэлт чухал уу?
- Шалгуур үзүүлэлт болон зорилтот түвшинд ашиглаж байгаа хэмжүүрүүд нь суурь үзүүлэлттэй ижил байна уу? жишээ нь Х орон нутаг дах завины тоо
- Тэдгээрийг чухал үзүүлэлтээр нь ангилсан уу?
- Дутагдаж буй чухал суурь үзүүлэлтийг хэмжих/үнэлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаа байна уу?

ГХХ-ний бүрдэл хэсгүүд : Зорилтот түвшин

- Төлөвлөгчид шалгуур үзүүлэлт болон зорилтот түвшний хоорондох ягааг ойлгож байна уу?
- Цаг хугацаа, төсөв, ажлын хүрээг харгалзан тэнд хүрэх боломжтой юу?
- Үзүүлэлтийг задлан цуглуулах нь ач холбогдолтой юу? Хэрэв тийм бол мэдээллийг өмнө нь задлан цуглуулж байсан уу?
- Суурь мэдээлэл болон шалгуур үзүүлэлтийн нэгж нь шинжилгээ болон хэмжих нэгжтэй тохирч байна уу?
- Төсөөтэй суурь үзүүлэлт: ГХХ-нд дутуу зорилтот түвшнийг хэмжих/үнэлэх ямар нэгэн үйл ажиллагаа төлөвлөсөн үү?

ГХХ-ний бүрдэл хэсгүүд : Мэдээллийн эх үүсвэр

- Төлөвлөгчид анхдагч болон хоёрдогч эх үүсвэр хоорондын ялгааг ойлгодог уу?
- Өгөгдлийн эх сурвалжийг нарийн тодорхойлсон уу?
- Тэд хэр найдвартай вэ? Ямар нэгэн өрөөсгөл тал бий юу?
- Тэдгээрийг хялбархан авах боломжтой юу?



ГХХ-ний бүрдэл хэсгүүд : Өгөгдөл цуглуулах аргууд

- Зохих түвшний нарийвчлалтайгаар аргуудыг тайлбарласан уу? Сөрөг жишээ: Хууль (эх сурвалж); Эерэг: шүүхийн практикт дүн шинжилгээ хийх
- Сонгож авсан аргууд нь хэрэгжүүлэгч түншүүдийн чадавхид нийцсэн үү?
- Сонгож авсан аргууд нь төсөв санхүүтэй уялдаж байна уу?
- Өмнө нь үндэсний болон бүсийн хэмжээнд тус аргуудыг хэрэглэж байсан уу?

ГХХ-ний бүрдэл хэсгүүд : Давтамж

- Тогтоосон давтамж нь хүчин чадал, боломж, төсөвтэй нийцэж байна уу?
- Давтамж нь шийдвэр гаргагчид (жишээлбэл, СЯ) болон хэрэгжүүлэгч түншүүдийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна уу?
- Сонгосон давтамж нь хөтөлбөр/бодлогын амьдралын мөчлөгийн туршид хэрэгжих боломжтой юу?

ГХХ-ний бүрдэл хэсгүүд : Хариуцлага

- Гүйцэтгэлийн хэмжих хүрээ нь гүйцэтгэлийн мэдээллийг цуглуулах, удирдах, баталгаажуулах, үнэлэх хамгийн тохиромжтой бүлгийг (жишээлбэл, үр шим хүртэгчид, орон нутгийн мэргэжилтнүүд, түнш байгууллагууд гэх мэт) тодорхойлсон уу?
- Сонгосон бүлэг нь өгөгдлийг цаг тухайд нь цуглуулах, удирдах, баталгаажуулах, үнэлэх чадавхи, боломжтой юу?

Хөтөлбөр болон бодлогын шинжилгээний элементүүд



Яам, агентлагаас УИХ хүртэл

Бодлого эсвэл хөтөлбөр батлуулах зөвшөөрөл хүссэн яам эсвэл агентлаг дараахь зүйлийг агуулсан өргөдлийн маягтыг бөглөх ёстой.

Тодорхойлолт:

- Агентлагийн санаачилгыг хэрэгжүүлэх төлөвлөгөө (зардал, хөрөнгийн эх үүсвэрийг оруулаад)
- Хүлээгдэж буй үр дүн
- Санаачилгатай холбоотой эрсдэлүүд (мөн өргөн хүрээний санаачилгын аливаа эрсдэл), түүний дотор санаачилгыг хэрэгжүүлэхгүй эрсдэл
- Сангийн яамнаас хүссэн шийдвэр(үүд).

Яам, агентлагаас УИХ хүртэл (үргэлжлэл)

СЯ-аас дараах зүйлийг харгалзан үзнэ:

- Санаачилгын эрсдэлийн түвшин
- Санаачилга нь хэр зэрэг тусгай арга хэрэгсэл шаардах вэ?
- Санаачилгыг маргаангүй гэж үзэж байгаа эсэх
- Санаачилга нь одоо байгаа санаачилгын нэг хэсэг үү? эсвэл шинэ санаачилга уу?
- Санал болгож буй санаачилга болон үр дүнгийн хэмжигдэхүүн хоорондын шалтгаан-үр дагаврын хамаарал.

Дасгал 4

Нэг үр дүнгийн тодорхойлолт сонгоод Гүйцэтгэлийн хэмжих хүрээний шаардлагатай бүх хэсгийг бөглөнө үү?.

Бүх мэдээлэл заавартай нийцэж байгаа эсэхийг үнэл.



ᠭᠢᠯᠠᠢᠯᠠᠭ᠎ᠠ

“Гялайлаа”





Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

Address: Floor 3, National Times News Tower Khudaldaanii
gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

Phone: 7610-5000